


Асуулт – Хариулт**2025.03.17****Асуулт №1. Талбай дахь тугийн байрлал ямар байх вэ?**

Хариулт №1. Баг тус бүр тэмцээний бэлтгэл хугацаа 5 минутад өөрсдийн харгалзах бүсийн “цуглуулах талбай”-д тугийг байрлуулна. Тугийг тэмцээний талбайд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүйгээр хүссэн байрлалаараа байрлуулж болно.

**Асуулт №2. Дээжийг хэрхэн байрлуулах вэ?**

Хариулт №2. Дээжийг тэмцээн зохион байгуулагч эсвэл шүүгчид байрлуулах олборлолтын талбайн цооногийн ёроолд байрлуулна. Дээж ямар ч байрлалаар байрлах боломжтой.

Асуулт №3 Талбайн хүрээ тууз байх уу? Хана босгох уу? Зураасан тэмдэглэгээтэй байх уу?

Хариулт №3. Зураасан тэмдэглэгээтэй байна

Асуулт №4 Хоёр жалганы ёроол тэгш өнцөгт байрлалаар уу дугуйрсан байх уу?

Хариулт №4. Тэгш өнцөгт байлгахыг эрмэлзэх боловч энгийн багажаар ухаж гаргах тул нарийн алдаагүй байх боломжгүй.

Асуулт №5 Багийн гишүүдийн тоог өөрчилж болох уу?

Хариулт №5. Болно

Асуулт №6 Жингийн хязгаарлалтад өөрчлөлт оруулж болох уу?

Хариулт №6. Жингийн хязгаарыг өөрчлөн робот нь 15кг -аас ихгүй жинтэй байхаар болов.

Асуулт №7 Батарейны хувьд хүчдэлийн хязгаар байгаа юу? Тавигдах шаардлага? Хуурай эсвэл шингэн Ямар ч төрлийнх байж болох уу?

Хариулт №7. Тодорхой шаардлага байхгүй. Гагцхүү аюулгүй ажиллагааг хангасан байна. Үүнийг “Шийдвэрлэх загварын хэлэлцүүлэг” -т танилцуулах ёстой.

Асуулт №8 Дүрс дамжуулалтын хувьд робот дээр хэдэн камер байж болох вэ?

Хариулт №8 Хэд ч байж болно.

Асуулт №9 Роботоос гадна талбайн хажууд гуравдагч өнцгийг хархаар камер байрлуулж болох уу ?

Хариулт №9 Болохгүй.

Асуулт №10 Робот эхлэхдээ камер нь дотроо байгаад анх эхэлсэн газраа камераа үлдээгээд явж болох уу?

Хариулт №10 (Дүрмийн нэмэлт өөрчлөлт)

5.2.1. Тэмцээн эхэлснээс хойш робот нь дүрмийн бусад заалтыг зөрчихгүйгээр 2 м (урт) х 2 м (өргөн) х 3 м (өндөр) эзэлхүүн бүхий орон зайн хэмжээст багтаж өөрчлөгдөж болно.

5.2.2. Робот нь нэгээс олон хэсэг болон хуваагдаж болох хэдий ч роботын бүх хэсэг нийтдээ 5.2.1 -д заасан орон зайгаас хэтэрч болохгүй

Асуулт №11 Робот талбайн хэмжээсийг агаараар давах боломжтой юу? Тэлсэн хэсэг нь агаараар буюу хилийн дээгүүр давбал гарсан гэж тооцох уу?

Хариулт №11: Талбайн хязгаар нь зурааснаас эгц дээш бүх орон зайг хамаарна. Тиймээс робот агаарын орон зайгаар талбайн хязгаарлах зураасыг давсан тохиолдолд талбайгаас гарсан гэж үзнэ.

Асуулт №12: Инновацын төрлийг ямар байдлаар шүүх вэ?

Хариулт №12: Тэмцээний шүүгч, зохион байгуулагчид шийднэ.

Асуулт №13: Робот гарааны бүснээс гараад олборлолтын эхний бүсээс дээжээ цуглуулахдаа гурван дээжээ нэг дор цуглуулаад буцаад цуглуулах бүсдээ байрлуулж болох уу? заавал нэг нэгээр гэсэн байгаа юу?

Хариулт №13: Болно. Гэхдээ эхлээд заавал олборлолтын 1-р бүсээс дээж авч байж олборлолтын 2-р бүсэд нэвтэрнэ. Үүнийг дүрэмд дараах байдлаар тодруулан оруулав.

7.3.1. Робот нь олборлолтын 1-р бүсээс ядаж нэг базальт бүрэн авч байж олборлолтын 2-р бүсэд нэвтрэх эрхтэй болно.

Асуулт №14 Олборлолтын 1-р бүсээс олборлосон дээжээ цуглуулах бүсэд байрлуулаад дараагийн бүс рүү явах уу?

Хариулт №14: Энэ бол тухайн багийн тоглолтын тактик, сонголтоос хамаарна. Олборлолтын 1-р бүсээс дээж аваад цааш олборлолтын 2-р бүсэд очиж болно.

Асуулт №15: Баг болгонд шаклтоны бүс байгаа юу?

Хариулт №15: Шаклтон бол хоёр багийн дундын бүс бөгөөд ганцхан ширхэг байгаа. Энэ бүсэд аль ч баг зөвхөн агаарын орон зайгаар нэвтрэх эрхтэй. Түрүүлж тугаа байрлуулсан баг цэвэр ялна.

Асуулт №16: Элс ногоон бүстэй 1 түвшинд байх уу?

Хариулт №16: Тийм

Асуулт №17: Базальт болон Гели-3 олборлох нүх цилиндрээр ухах уу эсвэл тогоолж ухаж байгаад цилиндр болгох уу ирмэг нь нурах магадлалтай юу?

Хариулт №16: Аль болох цилиндр байлгахын эрмэлзэнэ. Нүхний амсар хэсэг ёроол хэсгээс том байх магадлалтай. Мөн эрмэг нурах магадлалтай.

Асуулт №18: Робот явахдаа нүхээ дайраад гарч болох уу?

Хариулт №18: Тийм. Робот нүхийг дайрч гарч болно. Гэвч нүхийг гэмтээсэн тохиолдолд талбай гэмтээсэн гэдэг үндэслэлээр хасагдах нөхцөл бий болно.

Асуулт №19: Уул 2 талдаа хашлагагүй бүх талаасаа гол руугаа шовойсон байхаар робот хажуу тийшээ холбирах магадлалтай юу?

Хариулт №19: Уулыг хажуу гаргуугаас нь дээш 15 см өндөртэй модон хашлагаар хоёр талаас нь хашиж роботууд унахаас сэргийлнэ. Роботууд уул өөд өгсөх үед хашлагад хүрч болно. Гэвч хашлагаас дээгүүр агаарын орон зайгаар талбайгаас гарч болохгүй.